

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2022 ОНЫ ЖИЛИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БИЧМЭЛ ТАЙЛАН**
Ерөнхий мэдээлэл

Тус байгууллага нь төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд, төслийн нэгжийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнд үнэлгээ өгөх, хэрэглэгчийг мэдээллээр хангах зорилтоо ханган биелүүлж ажиллаа.

Тус алба нь албаны дарга санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч дотоод аудитор 1, санхүүгийн хяналт шалгалтын мэргэжилтэн дотоод аудитор 3, нягтлан бодогч бичиг хэргийн ажилтан 1 гэсэн үндсэн 6 орон тоотой ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын 4-т Санхүүгийн хяналт аудитын албаны нэршилийг “Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба” болгосны дагуу улсын бүртгэлийн гэрчилгээ, албан бланкуудад өөрчлөлт хийлгэсэн, албаны дүрэм, бүтэц орон тоог шинэчлэн батлуулсан.

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг чанартай гүйцэтгэх

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Санхүүгийн хяналт аудитын албаны дунд хугацааны стратеги төлөвлөгөө

1-р зорилт Төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор санхүүгийн хяналтын үр нөлөөг дээшлүүлж, эрсдлийн удирдлагаар хангаж ажиллана. Төсвийн тухай хуулийн 69-р зүйл, Засгийн газрын 483 дугаар тогтоол, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

1.1. Төсөвт байгууллагууд сан, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж, санхүүгийн хяналтын үр нөлөөг дээшлүүлж эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллах

2021 оны 12 дугаар сард аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчын харъяа байгууллагууд, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийж дунд эрсдэлтэй дүгнэгдсэн 51 байгууллагыг санхүүгийн хяналт шалгалтад хамруулах төлөвлөгөөг гарган аймгийн Засаг даргаар батлуулсан. 2022 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад 40 байгууллага хамруулсан. Төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч цаг үеийн шаардлагаар 13

байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийснээр нийт 53 байгууллагад хяналт шалгалт хийж гүйцэтгэл 103.9%-тай.

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг Орхонтуул, Түшиг, Баянгол, Цагааннуур, Зүүнбүрэн, Жавхлант гэсэн 6 сумын ИТХ, сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, ЭМТ зэрэг төсөвт байгууллагуудад хийлээ.

Санхүүгийн хяналт шалгалтаар 9905.7 мянган төгрөгийн зөрчил дутагдалыг төлүүлэх 9 акт тогтоосон, үүнээс улсын төсөвт 1506.5 мянган төгрөг, аймгийн төсөвт 4191.9 мянган төгрөг, сумын төсөвт 350.0 мянган төгрөг, байгууллагад нь 3104.5 мянган төгрөгийг төлүүлж, 2 ажилтанд 752.8 мянган төгрөгийг олгуулахаар шийдвэрлэлээ. Төлбөрийн 1 актын хугацаа болоогүй, 8 акт бүрэн барагдсан.

1.2.Төсөвт байгууллагууд сан, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагад дотоод аудит хийж, дүгнэлт өгөх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зөвлөмж өгөх

2022 онд 32 байгууллагад дотоод аудит хийхээр төлөвлөгөөнд тусгагдсанаас төлөвлөгөөт 25, төлөвлөгөөт бус 6 нийт 31 байгууллагыг хамруулан гүйцэтгэл 96.9%-тай.

Дотоод аудитын талаар тодруулахад:

- Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулах зорилгоор 2021 оны жилийн мэдээлэл байршуулалтад аудит хийж дүнг аймгийн Засаг даргад болон АТГ-т хүргүүлсэн.

Шилэн дансны аудитаар аймаг, сумын төсвийн ерөнхийлөн захирагч 18, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 11 байгууллага, аймаг, сумын ЗДТГ, ИТХ, сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, соёлын төв зэрэг төсвийн 161 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуй нэгж, үйлдвэрийн газар 13, өрхийн эмнэлэг 5, мал эмнэлэг 38, хүнсний талоноор үйлчилдэг 28 дэлгүүр, хувийн цэцэрлэг, сургууль 3, ахмадын холбоо 1 нийт 278 байгууллага, нэгжүүдийг хамруулж дүгнэхэд дунджаар 97.4%-тай дүгнэгдсэн

Аймгийн шилэн дансны ил тод байдалд сөргөөр нөлөөлсөн Шаамар сумын ЭМТ, Шаамар Соёлын төв, Шаамар сумын ТЕЗ, Ерөө сумын ТЕЗ, Орхон сумын ИТХ, аймгийн ОНӨ газар, Сэлэнгэ үржлийн цөм сүрэг ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудын удирдлагуудад үүрэг өгөх саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэний үр дүнд мэдээллээ нөхөн байршуулсан үр дүнд хүрлээ.

2022 онд шилэн дансны мэдээлэлд 3 удаа аудит хийж, мэдээллийг үнэн бодит байдлыг хангуулах, байгууллагын дарга, нягтлан бодогч нар солигдсон байхад өөрчлөөгүй байсныг засуулах, шинээр байгуулагдсан орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгжид эрх өгч шилэн дансанд мэдээллийг байршуулахаар болгосон.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаар: 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй цаг үеийн шинжтэй 19 хяналт шалгалт хийсэн. Үүнд:

1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл: Иргэн А.Отгонбаяр, Д.Ганбаатар, Сүхбаатар сумын 1-р цэцэрлэгийн багш ажилчид, 5-р сургуулийн ажилчид, Иргэний хэргийн шүүхээс 36 дугаар цэцэрлэгийн ажилтанд холбогдох шинжээчийн дүгнэлт, МХГ-аас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн Гаалийн газрын ажилчидтай хамааралтай өргөдлүүд нь цалин хөлс, тэтгэмжийн олголт тооцоотой холбоотой байсныг шалгаж хариуг хугацаанд нь өгсөн.

Туулын хишиг ОНӨААТҮГ-ын ажилчидаас ирүүлсэн өргөдлийн дагуу шалгаж 1500.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж байгууллагад нь төлүүлэх төлбөрийн акт тогтоож шийдвэрлэсэн, Сэлэнгэ хөгжил тохижилт ОНӨААТҮГ-тай холбоотой иргэнээс ирүүлсэн өргөдөлөөр шалгахад мал нядалгааны хөлсний тооцооноос дутагдуулсан 1604.5 мянган төгрөгийн дутагдал илэрч байгууллагад нь төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож шийдвэрлэсэн.

2. Дээд байгууллага албан тушаалтнаас ирүүлсэн, шилжүүлсэн өргөдөл:

Аймгийн Засаг даргаас шилжүүлсэн Гавшгай-Ус ОНӨААТҮГ-т хийх хяналт шалгалт, Туулын хишиг ОНӨААТҮГ-т хийх хяналт шалгалт, Шаамар сумын Засаг дарга, ЗДТГазартай холбоотой мэдээлэл, Шаамар сумын ИТХ-ын даргад хамааралтай өргөдөл, Цагааннуур сумын ЕБС-ийн захирал Г.Сугарын талаар сургуулийн Үйлдвэрчний эвлэлийн хороо, багш нарын ирүүлсэн өргөдөл нийт 5 өргөдлийг шалгаж хугацаанд нь дүгнэлт танилцуулгын хамт цаашид авах арга хэмжээний саналыг тусган аймгийн Засаг даргад болон холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн

3. Боловсрол Шинжлэх ухааны Сайдын ирүүлсэн хүсэлтээр Зүүнхараа дахь Политехникийн коллеж, Сүхбаатар суман дахь МСҮТ, Шаамар суман дахь МСҮТ-д санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит шинжилгээ хийж дүгнэлт, саналыг хүргүүлсэн.

4. Сангийн Сайдын баталсан нэгдсэн удирдамжаар Ковид-19 цар тахлын нийгэм- эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны Засгийн газрын 211 дүгээр тогтоолоор төрөөс үзүүлсэн дулаан, гэрэл цахилгаан, ус,хогны хөнгөлөлт чөлөөлөлтийн тооцоонд хяналт шалгалт хийж дүгнэхэд Сэлэнгэ аймгийн хэмжээнд дулаан, ус, хог, цахилгааны төлбөрт 2020 оны 12 дугаар сараас 2021 он дуусалх хугацаанд 32676 айл өрх, 3229 аж ахуйн нэгжийг 18868271569 төгрөг 97 мөнгийг (18 тэрбум найман зуун жаран найман сая хоёр зуун далан нэгэн мянга таван зуун жаран есөн төгрөг 97 мөнгө) төрөөс төлж хөнгөлөлт үзүүлэхэд хамруулсан, боловч Энгийн хог хаягдлын хураамжийн хөнгөлөлтийн 201311.8 мянган төгрөгийн нэхэмжлэхийг аймгаас тухайн хугацаанд бүрэн хүргүүлээгүйгээс хөнгөлөлтөд бүрэн хамрагдаагүй уг тогтоолын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэлт өгсөн.

Хяналт шалгалтын нэгдсэн дүн мэдээллийг Сангийн Яаманд болон аймгийн Засаг даргад хүргүүлж, 1506.5 мянган төгрөгийн зөрүүг Хөтөл Энержи дулаан ХХК-иар улсын төсөвт буцаан төлүүлэх акт тогтоон барагдуулсан.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ
САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Хяналт шалгалт, дотоод аудитын үр дүнд хөрөнгийн үр өгөөжийг сайжруулах, зөрчил, дутагдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах арга хэмжээний хүрээнд 2022 онд санхүүгийн хяналт шалгалтад 51, дотоод аудитад 32 байгууллага нэгж нийт 83 байгууллага хамруулахаар төлөвлөгөө батлагдсан. Гүйцэтгэлээр 84 байгууллага хамруулж, хяналт шалгалт дотоод аудит хийсэн ажлын биелэлт 101.2%-тай байна.

Бодлогын чанартай дэвшүүлсэн санал, шийдвэрлэлт:

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашигт байдалд хуулийн хүрээнд зарцуулах, салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой цаашид шийдвэрлүүлэх шаардлагатай санал дүгнэлт гаргадаг. Иймээс хийсэн хяналт шалгалтын дүнд үндэслэн 2022 онд дараах саналуудыг хүргүүлсэн.

-Сангийн Яаманд шилэн дансны мэдээлэл давхарддаг, ачаалал ихтэй цаг хугацаа их шаардагддаг хүндрэл гарч байгаа тул өөрчлөлт оруулах санал,

-Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргад Шилэн дансанд мэдээлэл хангалтгүй байршуулсан 8 байгууллагын мэдээлэл 63-85%-тай байгаа талаар мэдээлж үүрэг чиглэл хүргүүлсэн, 6 сумын ТЕЗ-ын санхүү төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын дүнг мэдээлж дээрх сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргаас зөвлөмж хүргүүлсэн.

-Үндсэн чиглэл, үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн хэрэгжилт:

№	Үндсэн чиглэл, хөтөлбөр	Төлөвлөсөн арга хэмжээний заалтуудын хэрэгжилт
1	Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	6 заалтаас 4 заалт 100%, 1 заалт 98%, 1 заалт 80%-тай дундаж 96%-тай
2	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5 заалт 100%, 1 заалт 94.8%, 1 заалт 95.6%, 1 заалт 96.9 хэрэгжсэн, дундаж 98.4%
3	Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт	4 заалт 100%, 1 заалт 95% дунджаар 99% хэрэгжсэн

4	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний 2020-2023 оны төлөвлөгөөний биелэлт	4 заалтын дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна 100%-тай
5	Аймгийн "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа" хөтөлбөрийн 2022 онд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл	17 арга хэмжээнээс 12 ажил 100%, 2 ажил 80%-тай огт хэрэгжүүлээгүй 1, дунджаар тооцоход 91.8%-тай хэрэгжилттэй
6	Аймгийн "Суралцагч байгууллага-төрийн албаны манлайлал" аймгийн хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт	огт хэрэгжээгүй 1, 50%-тай 1, 80%-тай 6, 100%-тай 47 заалт, дунджаар 96.9%-тай.
7	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөрийн хэрэгжилт	4-р заалт 100%-тай
8	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	5 заалт 100%, 1 заалт 94.8%, 1 заалт 75% дундаж 95.8%

Дээрх хөтөлбөр үйл ажиллагааны чиглэлийн хэрэгжилтийг хангахын тулд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/1436 дугаартай “Үүрэг, чиглэл өгөх тухай” албан бичгээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу тус байгууллагад хамааралтай дараах 12 арга хэмжээг төлөвлөн 92.0%-тай хэрэгжүүлсэн . (хэрэгжилтийг хавсаргав)

ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Сангийн Сайдын олгосон улсын ахлах байцаагчийн эрх үүргийн хүрээнд 2022 онд хийсэн хяналт шалгалт, дотоод аудитаар 1232594.0 мянган төгрөгийн мөнгөн төлбөр зөрчил болон, үйл ажиллагаа, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 185 зөрчил илрүүлж 168 зөрчлийг арилгуулсан.

3.1. Төлбөрт тогтоосон акт:

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 9905.7 мянган төгрөгийн 9 акт тогтоосоноос улсын төсөвт 1506.5 мянган төгрөг, аймгийн төсөвт 4191.9 мянган төгрөг, сумын төсөвт 350.0 мянган төгрөг, байгууллагад нь 3104.5 мянган төгрөгийг төлүүлж, 2 ажилтанд 752.8 мянган төгрөгийг олгуулахаар шийдвэрлэлээ.Төлбөрийн 1 актын хугацаа болоогүй, 8 акт бүрэн барагдсан.

Төлбөрийн актуудын талаар:

-Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлангийн баталсан нэгдсэн удирдамж, аймгийн Засаг дарга Н.Лхагвадоржийн баталсан удирдамжаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулаан, уур, ус, хогны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлт,

үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн тооцоог шалгаж 1506.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж Хөтөл Энержи дулаан ХХК-иар улсын төсөвт нөхөн төлүүлсэн.

-Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлангийн баталсан нэгдсэн удирдамж, аймгийн Засаг дарга төсвийн ерөнхийлөн захирагч Н.Лхагвадоржийн баталсан удирдамжаар “хууль бус шийдвэрийн улмаас төрд хохирол учруулсан эсэх”-д хяналт шалгалт хийж 4191.9 мянган төгрөгийн төсвөөс төлсөн зөрчил илрүүлж аймгийн төсөвт төлүүлэх акт тогтоосоноос 1191.9 мянган төгрөгийг төлүүлсэн.

-Алтанбулаг сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч н.Лхагважавт ажилласаны хугацааны 612.6 мянган төгрөг, Түшиг сумын ЭМТ-ийн эрхлэгчид үр дүнгийн гэрээний урамшууллын зөрүү 140.2 мянган төгрөгийг акт тогтоон олгуулсан

-Шаамар сумын ЗДТГ-т данснаас хасагдсан автомашины үнэ төлөгдөөгүй байсны 350.0 мянган төгрөгийг төлүүлж сумын орлого болгосон, Орхонтуул сумын Туулын хишиг ОНӨААҮГ-т бусдад ашиглуулж байсан 1500.0 мянган төгрөгийг төлүүлж байгууллагын нь орлого болгуулсан

-Сүхбаатар хөгжил тохижилт ОНӨААТҮГ-ын мал нядалгааны хөлсний тооцооны зөрүү 1604.5 мянган төгрөгийг кассын няравуудаар төлүүлэх 3 акт тогтоосоноос 664.5 мянган төгрөгийг төлүүлж 940.0 мянган төгрөгийн төлбөрийг төлөхгүй байгууллагыг хохироосон тул хуулийн байгууллагад шилжүүлсэн

3.2. Зөрчил арилгуулах албан шаардлага

-Сайхан сумын Гавшгай-Ус ОНӨААТҮГ-т 1177823.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулан байгууллагын эргэлжтийн хөрөнгийн эргэцийг нэмэгдүүлэх албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулсан.

-Орхонтуул сумын Засаг даргад шилэн дансны мэдээлэл, санхүүгийн тайлагнал, дотоод хяналтыг хэрэгжүүлэх албан шаардлага өгч биелэлтийг хангууллаа.

-Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуульд төгсөгч нараас хандивласан 44765.0 мянган төгрөгийг төсвөөс гадуур зарцуулаад хийсэн ажлыг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгуулах албан шаардлага, хүргүүлсэн.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА

Гүйцэтгэлийн зорилт № 4.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах арга хэмжээний хүрээнд

4.1.1 Төрийн захиргааны ажил үйлчилгээг хангах ажил арга хэмжээний хүрээнд:

Санхүүгийн хяналт аудитын албаны даргаас байгууллагын тасралтгүй ажил үйлчилгээг явуулж байгууллага хамт олноо удирдан чиглүүлж, хувь хүн бүрийн оролцоог жигд хангуулах, багаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байранд шинэ залуу албан хаагчдыг сургаж дадлагажуулах, туршлага судлуулах ажлыг хийж хамт олноо манлайлан ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/1436 дугаартай албан бичгээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу байгууллагад хамааралтай 12 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг 98.0% ханган биелүүллээ.(хавсралтаар гаргасан)

-Хүний нөөц, төрийн албан хаагчдыг хөгжүүлэх ажил

Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйг сахиулах, албан хаагчдыг ажлын байранд сурч хөгжихийг дэмжин ажиллав.

-2022 онд А.Энх-амгалан 23, Э.Наранбаяр 28, О.Базаррагчаа 23, Х.Оюунчимэг 26, Л.Байгалмаа 7 байгууллага нэгжид хяналт шалгалт дотоод аудит хийсэн. Дотоод аудит нь цаг хугацаа их шаарддаг, ажлын баримт санал асуулга авах, дүн шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагааг хамардаг энэ чиглэлээр Э.Наранбаяр, О.Базаррагчаа нар тэргүүлэн ажиллаа.

Төрийн албаны шинэтгэлийн бодлого, төрийн албаны болон хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, төрийн албан ёс зүй сахилга, хариуцлагыг сайжруулах, төрийн үйлчилгээ-байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн шинэлэг онцлог ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг 100% ханган биелүүллээ.

-Ажилтан албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт:

Байгууллагынхаа ажилтан албан хаагчдыг мэргэшүүлэх болон мэдлэг чадвар, харилцааны хандлагыг төлөвшүүлэх сургалтад хамруулан “суралцагч байгууллага” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаа.

-Төрийн албаны салбар зөвлөлөөс эрхлэн зохион байгуулсан албан хаагчдын идэвхи оролцоог нэмэгдүүлэх, харилцан хүндэтгэл итгэлцэл бүхий орчныг бүрдүүлэх тухай, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн зэргийг үнэлэх журам, төрийн удирдлагын инновацид дизайн сэтгэлгээ аргачлалыг ашиглах зэрэг сургалтууд, нийгмийн халамж үйлчилгээний газраас эрхлэн зохион байгуулсан хөдөлмөрийн хуулийн өөрчлөлт, хэрэгжүүлэх сургалтад хамруулсан.

-Дотоод аудитын аргачлал шинээр батлагдсан тул ажлын байранд ажилтнуудыг зааж сургах ажлыг хийж 40 цагийн ажлын байрны сургалт хийлээ. Сонгино хайрхан, Баянгол дүүргийнхэнтэй хамтран сургалт зөвлөгөөн хийж харилцан туршлага солилцох ажил хийлээ.

-Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс зохион байгуулсан төрийн сангийн төлбөр тооцооны цахим систем нэвтрүүлэхтэй холбоотой сургалтад 2, шилэн дансны шинэ систем нэвтрүүлэх цахим сургалтад 6 албан хаагч оролцсон.

- Мэдээлэл, ил тод байдлын талаар:

Санхүүгийн хяналт шалгалт, аудитын дүн мэдээг байгууллагын самбарт 12 удаа, Сэлэнгэ аймгийн албан ёсны цахим сайт, байгууллагын цахим хуудсанд 12 удаа, аймгийн Статистик мэдээнд 4 удаа мэдээлж, Шилэн дансанд

байгууллагын мэдээ тайланг хугацаанд нь шивж оруулан төсөв санхүү, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаа.

Байгууллагын цахим хуудсанд тавигдсан мэдээлэл нь төсвийн менежер, нягтлан бодогч, бүртгэлийн ажилтан зэрэг 1155 албан тушаалтанд шууд цахимаар хүрдэг болсон.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн Захирагчын харъяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтад 2022 онд 3 удаа аудит хийж, мэдээлэл буруу байршуулсан байгууллагуудад 24 албан бичиг хүргүүлж, утсаар зөвлөмж өгч төсөв санхүүгийн ил тод байдлыг хангуулж, мэдээллийг албан ажлын гадна самбарт улирал бүр мэдээлж иргэдэд хүргэлээ.

-Баримт бичиг шийдвэрлэлт

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, журмын хөтөлж, хэвлэмэл хуудасны зарцуулалтад хяналт тавьж, хариутай бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилт, хяналт шалгалтын акт албан шаардлагын биелэлтийн албан бичгийг бүртгэж, хяналт шалгалтын танилцуулга, акт, албан шаардлага, байгууллагын даргын тушаал, албан бичгийн бланк хэвлүүлэн ашиглаж байна.

-Удирдлагын баримт бичгийн хүрээнд Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны А/462 дугаар захирамжаар батлагдсан “Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг бүрдүүлэх журам”-ын дагуу 28 тушаал гаргаж, хувийн хэргийн бүрдэлтийг ханган ажиллаа.

2022 онд 176 албан бичиг ирүүлснээс хариутай 68 бичгийн хариуг хугацаанд нь шийдвэрлэж хүргэсэн, 132 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

-Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа

Санхүүгийн үйл ажиллагааны тайланг төсвийн тухай хууль Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад нийцүүлэн, НББ-ийн бодлогын баримт бичигт тулгуурлан, холбогдох эрхзүйн актууд тэдгээрийг дагаж мөрдөх зарчмуудад тулгуурлан тайлагнасан.

Тайлант онд орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд 200999.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан, гүйцэтгэлээр 196489.6 мянган төгрөг зарцуулж, төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж 4510.1 сая төгрөгийг хэмнэж, өр авлага үүсгэлгүйгээр ажилласан. Шилэн дансны мэдээллийг 100% мэдээлж, байгууллагын гаднах мэдээллийн самбарт гүйцэтгэлийг байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаа.

4.1.2. Бүтээлч, нийтийг хамарсан ажил үйлчилгээний арга хэмжээний хүрээнд:

Санхүүгийн хяналт аудитын албанаас 2022 онд 2 чиглэлээр бүтээлч ажил хийхээр төлөвлөж 100% хэрэгжүүллээ. Үүнд:

1. Байгаль орчныг тохижуулах, орон нутгаа хөгжүүлэхэд оролцох

-Нэг тэрбум модны хөтөлбөрт байгууллагаараа оролцож Тужийн нарсанд болон Сүхбаатар сумын Хулан хотны цогцолборт мод тарьсан, орчны болон нийтийн хог цэвэрлэгээнд оролцож ажиллаа.

2. Санхүү төсвийн зөрчлийг бууруулахаар төсвийн захирагч, санхүүгийн ажилтнуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургах ажил хийх

-Баянгол, Түшиг, Орхонтуул, Цагааннуур, Зүүнбүрэн сумдад хяналт шалгалт хийх хугацаанд төр төсвийн 40 байгууллагын захирал, дарга эрхлэгч, нягтлан бодогч, нярав нарт 5 удаа танхимын сургалт, 11 байгууллагын нягтлан бодогч нарт цахимаар сургалт хийсэн.

-Аймгийн 120 албан тушаалтныг хамруулсан сургалтыг Сангийн Яамны НББГ, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттай хамтран зохион байгуулж санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэх, анхан шатны баримтын бүрдэлтийг хангах, шилэн дансанд мэдээллээ хэрхэн өөрчлөх, нөхөн байршуулах, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр хичээл зааж дадлагын ажил хийлгүүлээ.

-Нягтлан бодох бүртгэлийн хууль, Шилэн дансны мэдээлэл, байгууллагын хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээний талаар гарын авлага боловсруулж хэвлэн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, сумын Засаг дарга, нягтлан бодогч, төсвийн байгууллагын дарга эрхлэгч нарт 100 ширхэгийг тараан өгч сурталчилсан.

ТАВДУГААР ХЭСЭГ . 2022 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчаас 2022 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ажил үйлчилгээг тасралтгүй явуулж байгууллага хамт олноо удирдан чиглүүлж ажилласнаар үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтот арга хэмжээг 94.8%-тай ханган биелүүллээ.

Санхүүгийн хяналт шалгалтад 53, дотоод аудитад 31 нийт 84 байгууллагыг хамруулан төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанаас 185 зөрчил илрүүлсэн. Зөрчил дутагдлыг арилгуулахаар 1222688.3 мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагыг 3 албан тушаалтанд өгч, 9905.7 мянган төгрөгийн 9 акт тогтоож, төсөв санхүү шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй зөрчил дутагдал гаргасан 8 ажилтанд арга хэмжээ авахуулах саналыг байгууллагын удирдлагад хүргүүлж мэдээллийг нөхөн мэдээллүүлсэн.

Өнгөрсөн 2021 онд санхүүгийн хяналт шалгалтад 50, дотоод аудитад 16 нийт 66 байгууллагыг хамруулж байсан бол тайлант онд шинээр төрийн албаны тусгай шалгалт өгсөн 3 ажилтантай болсноор хяналт шалгалт хийх боломжтой болсноор 84 байгууллага нэгжид хүрч эрсдэлтэй байгууллагуудад хяналт шалгалт

дотоод аудит хийсэн нь зөрчил дутагдал буурах, төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдан тайлагнахад үр дүнгээ өгч байна.

Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэхийн тулд аймгийн ИТХТ-ийн 2017 онд баталсан “дотоод аудитын хороо”г татан буулгах санал хүргүүлж шийдвэрлүүлсэн. Шинээр дотоод аудитын хороо байгуулах захирамжийг төслийг хүргүүлсэн.

Байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний бичмэл тайланг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам” 2021 оны 374 дүгээр тогтоолыг баримталсан болно.

Хяналт шинжилгээ үнэлгээний тоон мэдээлэлийг хавсаргав.Үүнд:

- Санхүүгийн хяналт шалгалт дотоод аудитын нэгтгэсэн тоон мэдээлэл 2 х
- Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийсэн байгууллагын жагсаалт, ажилтан бүрээр 3 х
- Төлбөр зөрчилд тогтоосон 1232594.0 мянган төгрөгийн акт, албан шаардлагын жагсаалт 1х
- Төлбөрийн актыг улсын төсөв, аймаг орон нутгийн төсөвт, байгууллагад төлүүлсэн иргэнд олгуулснаар ангилсан судалгаа 1х

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.ДАРИХЖАВ

Зураг № 1. Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2022 оны 09 сарын 22-нд аймагт зохион байгуулсан 120 нягтлан бодогч оролцсон сургалтыг аймгийн Засаг даргын орлогч С.Сайнцог нээлээ.



Зураг № 2. Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга Б.Дарихжав “Шилэн дансны мэдээлэл, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналт” сэдвээр илтгэл тавьсан. 2022 оны 09 сарын 22



Зураг № 3. 2022 оны 09 сарын 22 нд 120 нягтлан бодогч сургалтад оролцсон



Зураг № 4. 2022 оны 09 сарын 22 нд 120 нягтлан бодогч сургалтад оролцсон



Зураг № 5. Орхонтуул суманд хийсэн сургалт



Зураг № 6 Түшиг суманд хийсэн сургалт



